



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 03 сарын 05 өдөр

Дугаар 45

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө олж авах зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Худалдаа, Үйлдвэрлэлийн Их Сургуулийн Удирдах зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн “Төсөв батлах тухай” 15 дугаар тогтоолын дагуу тус сургуулийн албан хэрэгцээнд зориулан нийт 180,447,350.00 (нэг зуун наян сая дөрвөн зуун дөчин долоон мянга гурван зуун тавин) төгрөгт багтаан хавсралтад заасан төсөл арга хэмжээг өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх замаар үндсэн хөрөнгө олж авахыг зөвшөөрсүгэй.

2.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баярсайхан, Худалдаа, Үйлдвэрлэлийн Их Сургуулийн захирал М.Должин нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.


3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА


Б.ГАНБАТ

А.АРИУНБОЛД



0000151

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2019 оны 03 дугаар сарын 05 ны өдрийн
45 дугаар тогтоолын хавсралт



Худалдаа, Үйлдвэрлэлийн Их Сургуулийн 2019 онд хэрэгжүүлэх
 төсөл, арга хэмжээний жагсаалт

Д/д	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг
		(мян.төгрөг)
Барилга байгууламж		
1	Оюутны байрны хажуугын замыг хавтангаар хучих ажил /23*8/	16,164.40
2	Оюутны байрны засвар /агааржуулалт/	13,302.10
Бүгд дүн		29,466.50
	Биет бус хөрөнгө	
3	Санхүүгийн програм	1,870.00
Бүгд дүн		1,870.00
4	Ном худалдаж авах бүгд дүн	20,000.00
5	Тоног төхөөрөмжийн бүгд дүн	81,990.85
6	Тавилга эд хогшлын бүгд дүн	47,120.00
		180,447.35
НИЙТ ДҮН		(нэг зуун наян сая дөрвөн зуун дөчин долоон мянга гурван зуун тавин)